



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
**ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР**

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.04.12 № 03/565

танай _____-ны № _____-т

Төсөл, арга хэмжээний талаар

Тус газраас зарласан Сургууль, цэцэрлэгийн тоног төхөөрөмж (Улаанбаатар, Баянгол дүүрэг) БШУЯ/20240102231 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах төсөл арга хэмжээний тендер шалгаруулалтын материал хүлээн авах, нээх хугацааг хойшлуулж байна.

Тендерт оролцогчоос тодруулга ирүүлсэн бөгөөд тодруулгын хариуг мэргэжлийн байгууллагуудаас авахад хугацаа шаардлагатай байгаатай холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсэгт заасан захиалагч тодруулга авах хүсэлт хүлээн авснаас хойш тодруулгын хариуг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр гаргах гэснийг хангах боломжгүй нөхцөл байдал үүссэн тул:

1. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 26.1-д заасан Тендер хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 00 минут хүртэл
2. ТШЗ 26.2: Тендер нээх хугацааг 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 10 цаг 30 минут болсныг үүгээр мэдэгдэж байна.

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсэгт зааснаар Тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.